

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Мөнхнямын Мэнддаваа	Дугаар	LO30
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Баянгол дүүрэг
Төрсөн газар	Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сум	Төрсөн он	1920
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Сайн ханы хүрээ	Сүм хийдийн дугаар	ӨХУЯ 027
Одоогийн сүм хийд	Гандантэгчинлэн хийд	Сүм хийдийн дугаар	UB 01
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 11-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Өвөрхангай аймгийн Уянга сумын Сайн ханы хүрээ

Өвөрхангай аймгийн Уянга сумын хүрээ. 30 шахам дугантай байсан.

Сайн ханы хүрээ Төгс-Очирын урд Амбан ноён гэж байсан. Тэр ноёны үед байгуулагдсан гэдэг. Манай хүрээ ямпайтай байсан. Энэ нь Манжийн хааны зөвшөөрлийн тэмдэг юм. Жанчивлан дацанд хурж байсан. Жанчивлан гэдэг маань Бодьсадын хийд гэсэн утгатай. Хошуу нь дотроо зүүн баруун гэж хуваагдана. Сүм, хошуу бүхэн өөртөө хийд байгуулсан. Тэр бүхэнд өөрсдийн хөрөнгөөр тусгай дуган барьсан. Би Бага баруун сум буюу Нарийнтээл, Хайрхандулаан сумын хүн. Хийдээс Уушхай гэдэг хүн чулууг тахидаг байсан. Уушхайг хилэгнүүлбэл мэдэгдэм аюул зовлон болдог байсан гэж хэлдэг байсан.

Хан Хөгшиний хошуу гэж байсан. Бага баруун сум Жанчивлан дацанд хурж байсан. Их баруун сум баруун дацанд, Тэргүүн баг нь Жимбэлэн дацанд, Хондого нь Дандарлин дацанд хурдаг байсан юм. Эдгээрээс

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хамгийн хатуу нь Голын дацан байсан. Сум дацангуудаас Цанидын дацанд хурна. Мөн Чойр, Жүд, Дүйнхор, Манбад хурж болно. Ядмынх гэж байна. Мөн хувилгаан багшийн Цанидын дуган байсан. 1000 бурханы дуган гэж байсан. Тэнд дом хурдаг байсан. Би Чойрт хурж байсан. Чойрт лав 5 жил сурсан. Хийдээс дондонжү зиндаатай гарсан.

Өдөр тутам цогчэн хурна. Өвөл, зун нэг нэг удаа цам гарна. Зуны адаг сарын шинийн 8-нд гарна. Зуны адаг сарын шинийн 1-нд Майдар эргэнэ. 100 гаран дүртэй цам гарна. Гомбо, Гонгор, Чойжоо, Улаан сахиус хоруудтайгаа гарна. Ганжуур хүрээгээ тойроод эргэнэ. Нэг өдөр л эргэнэ. 100-аад хүн цугладаг байсан байх.

Хувилгаан багш бүгдийн тэргүүн. Жанчивлангийн ловон Түдэв гэдэг лам байсан. Унзад нар жил бүр солигдоно. Чойрын шунлайв Цэрэнбалжир, Цэрэнпунцаг гэж байсан. Хүрээний цогчэн унзад нь Лувсанжамбал, гэсгүй Давааринченбэ, Гончиг гэж байсан.

Манбад хурж байсан. Хүүхдүүд Манла уншина. Зурхайч нар Дүйнхорт хурна. Гүнрэгийг Жүдэд хурна. Чойр, Цанидад орох хүн бол Цогчэн уншлагаа дуусгаж байж орох ёстой. Манбад гол төлөв Манлаа хурна. Ямар ч үед судас барьж үздэг байсан. Жүдэд Сандуй, Дэмчиг, Гүнрэг үзнэ. Манай хийдэд 4000 гаруй лам байсан. Жанчивланд 100 гаруй, Дандарлинд 30-40,

Жимбэлэнд 50-60, Баруун дацанд 100, Голын дацанд 100 хавьцаа лам байсан. Гавж нар олонгүй. Аранжинбын миндагтай хүн олон байсан. Ноёны байгуулсан өргөөнд очиж аграмбын дамжаа барьдаг байсан. Дорж, Шийлэг, Бадарч, Өлзийбат гэсэн аграмбууд байдаг байсан. Аранжинбыг өвөрлөгч хошуунд хийдэг байсан. Аранжинба улсууд л дээд тушаалд их ордог байсан.

Баруун Эрээт гэж дуган байсан. Хүрээнээс 10-15 км зайтай. Мөн Зүүн Эрээт гэж байсан.

Би 15 настай 1936 онд хар болж хөдөө гарсан. Мал малласан. 1939 онд цэрэгт явсан. Цэрэгт 6 жил их бууны ангид алба хаасан. Цэргээс ирээд сумын дарга, нэгдлийн даргаар ажиллаж байсан. 1982 онд тэтгэвэрт гарсан. 1992 оноос эргэж лам болоод хуралд хурж байна.